

АГУУЛГА

ОРШИЛ	3
1.1. Төслийн товч тодорхойлолт	4
ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	12
Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	12
Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	12
Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	12
Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	12
1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	18
4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
5. ТҮҮХ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДУРСГАЛТ ЗҮЙЛС	19
6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	23
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГЫН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	26

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Ашиглалтын технологи	5
Хүснэгт 2. Угаах процесст зарцуулагдах усны хэрэгцээ	9
Хүснэгт 3. Уурхайн нийт усны хэрэглээ	9
Хүснэгт 4. Ил уурхайн цахилгаан хэрэглэгчид	10
Хүснэгт 5. Уурхайн барилга байгууламжуудын байршил, эзлэх талбай	10
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах, тэр бум мод	18
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	24
Хүснэгт 12. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	25
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	26
Хүснэгт 14. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	27

ОРШИЛ


Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших Цагаан чулуут хоолойн дээд хэсэг нэртэй MV-003108 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2024 оны Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, болон бусад материалд үндэслэн БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А-618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу боловсруулав.

“Цагаан чулуут хоолойн дээд хэсэг” нэртэй 380.32 га бүхий MV-003108 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 10-р сарын 10-ны өдрийн 51 тоот шийдвэрээр “ХОТУ” ХХК-д шилжүүлсэн байна. Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын доод давхарга нь алттай дан давхаргаас бүрдэх ба харьцангуй бага уналтай тэвш маягийн U хэлбэрийн хөндийг дагаж тогтсон, аллювиаль-пролювиаль гаралтай голын сэвсгэр хурдсанд хуримтлагдсан, тууз хэлбэрийн энгийн тогтоцтой, III бүлгийн орд юм. Ордын ашигт давхарга суналын дагуу тогтоогдсон бөгөөд ерөнхийдөө тууз хэлбэрийн тогтоцтой алт агуулсан хурдас нь нийлмэл тогтоцтой, дунд зэрэг мөлгөржсөн, 700 метр урттай, дундаж өргөн 60 метр, дундаж гүн 21 метр байна.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн товч тодорхойлолт

Газар зүйн байршил: “Цагаан чулуут хоолойн дээд хэсэг” нэртэй MV-003108 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй судалгааны талбай нь засаг захиргааны хуваариар Монгол улсын зүүн хойд хэсэг, Дорнод аймгийн Баяндун сумын нутагт харьяалагдах бөгөөд улсын геодезийн нэгдсэн номинклатурын М-49-95, 96 хавтгайд байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 704 км, Баяндун сумаас хойд зүгт 35 орчим километрийн зайнд байрлана.



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

1.2. 2024 оны уулын ажлын төлөвлөлт

Ордыг ашиглах технологи. Ордыг ил аргаар ашиглах бөгөөд уулын ажил явуулах ашиглалтын системийг ордын уул-геологийн нөхцөл, геологийн тогтоц, ордын ашиглалтын хэтийн төлөв байдал зэргийг үндэслэн тээвэртэй гадаад, дотоод хосолмол овоолготой ашиглалтын системээр явуулахаар төлөвлөв.

Доголын өндөр: Уурхайн хөрсний зузаан болон элсний зузааны нийлбэр дунджаар 23 м байна. Тиймээс ажлын доголын өндөр 3.5 м ажлын бус догол 7 м байхаар төлөвлөв. Доголын аюулгүйн зай 2.5 м, траншейн 10 градус.

Ажлын доголын хажуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож $\alpha=55$ градус байхаар сонгосон.

Доголын өндөр: Уурхайн хөрсний зузаан болон элсний зузааны нийлбэр дунджаар 23 м байна. Тиймээс ажлын доголын өндөр 3.5 м ажлын бус догол 7 м байхаар төлөвлөв. Доголын аюулгүйн зай 2.5 м, траншейн 10 градус.

Ажлын доголын хажуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож $\alpha=55$ градус байхаар сонгосон.

Хүснэгт 1. Ашиглалтын технологи

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процесс
Авто тээвэртэй ашиглалтын систем	Хөрс хуулалт	Ухаж ачих
		Тээвэрлэх /Гадаад, дотоод овоолго/
	Элс олборлолт	Ухаж ачих
		Тээвэрлэх /Угаах үйлдвэр/

Ажиллах горим. Уурхай нь 2024 онд 3-р сарын 01-ээс бэлтгэл ажлыг эхлүүлж, 4-р сарын 1-ээс 9-р сарыг дуустал хөрс хуулах, элс олборлох, элс угаах, нөхөн сэргээлт хийх болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 12 цагийн уртасгасан хугацаагаар явагдана. Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон угаан баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Хүснэгт 5. Уурхайн ажиллах горим ба хугацаа

№	Үзүүлэлтүүд	Хугацаа	Эхний жил
1	Хуанлийн өдөр	хоног	365 хоног
2	Уурхайн бэлтгэл ажлын хоног	хоног	30 хоног
3	Жилд ажиллах ажлын хоног	хоног	180 хоног
4	Баяр ёслол	хоног	7 хоног
5	Төлөвлөгөөт бус сул зогсолт	хоног	13 хоног
6	Уурхайн цэвэр ажлын хоног	хоног	160 хоног
8	Баяжуулах хэсгийн ажиллах хоног	хоног	130 хоног
9	Хоногийн ээлжийн тоо	-	2
10	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12 цаг

Ил уурхайн хүчин чадал, техник-технологи

Ил уурхайн хүчин чадал. 2024 оны 3-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж, Цагаан чулуут хоолойн уурхайд манай компанид бэлэн байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд уулын ажлаар 48.2 мян.м³ алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж. Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа техник, тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан үргэлжлүүлэн ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан 2024 оны бүтээлийн тооцоог гүйцэтгэв.

Ил уурхайн үндсэн технологийн процесс нь өнгөн хөрсийг бульдозероор хуулж овоолгод байршуулах, хөрсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж гадаад, дотоод овоолгод байршуулах, алттай элсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж баяжуулах үйлдвэрийн хажууд овоолгод байршуулах зэрэг ажил гүйцэтгэнэ.

Ил уурхайн үндсэн хэмжээсүүд. Ордын хөрсний зузаан 2024 онд 21-23 м, элсний зузаан 1.9-2.1 м байгаа тул уурхайн гүн 25 м орчим байхаар байна. Иймээс хөрс хуулалт, элс олборлолтын ажил болон ил уурхайд ажиллах техник тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг үндэслэн ил уурхайн үндсэн хэмжигдэхүүнийг дараах байдлаар сонголоо.

Хүснэгт 6. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1	Хөрс хуулалтын доголын өндөр	м	3.5
2	Элс олборлолтын доголын өндөр	м	2
3	Мөргөцгийн налууугийн өнцөг	градус	55 ⁰
4	Авто замын өргөн	м	12
5	Авто замын налууугийн хэмжээ	%	80
6	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн	м	20

2024 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2024 оны 03-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Тухайн жилд ашиглах блокуудын шимт хөрсийг ялган бульдозероор түрж блокын хилийн гадна шимт хөрсний овоолгод байршуулж үндсэн хөрсийг экскаватор, автосамосвал ашиглан гадаад болон дотоод овоолгод шилжүүлэн байршуулахаар төлөвлөв.

2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр цагаан чулуут хоолойн доод давхаргын 1-В, 2-В, 3-В гэсэн блокуудыг олборлоно. Энэ онд 691.5 мян.м³ хөрс хуулж, химийн цэврээр 18.4 кг алт бүхий 48.2 мян.м³ элс олборлоно. Энэ онд уурхайн урт 490 м, өргөн дунджаар 100 м, уурхай нийт 5 га талбайг эзэлж байна.

Календарь төлөвлөлт


Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг жилийн хүчин чадал, ордыг ашиглах хугацаатай уялдуулж 2024 онд 48.2 мян.м³ элс олборлон баяжуулахаар тооцлоо.

Хүснэгт 7. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 онд			Нийт
			II-р улирал	III-р улирал	IV-р улирал	
1	Уулын цул	мян.м ³	216.8	322.5	200.4	739.69
2	Нийт хөрс хуулалт:		201.5	301.6	188.4	691.51
	Үржил шимт хөрс хуулалт	мян.м ³	9.0	6.0		14.94
	Хөрс хуулалт	мян.м ³	192.5	295.6	188.4	676.57
3	Элс олборлолт	мян.м ³	15.3	20.9	12.0	48.2

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

4	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	13.2	14.4	15.7	14.4
5	Угаах элсний хэмжээ	мян.м ³	15.3	20.9	12.0	48.18
6	Дундаж агуулга	мг/м ³	552.3	448.4	425.8	475.7
7	Металлын хэмжээ /шлихээр/	кг	8.4	9.4	5.1	22.92
8	Металлын хэмжээ /химийн цэврээр/	кг	6.8	7.5	4.1	18.41
9	Металл авалт	%	92.83	92.83	92.83	92.83
10	Металлын хэмжээ /шлихээр/	кг	7.8	8.7	4.7	21.28
11	Металлын хэмжээ /химийн цэврээр/	кг	6.3	7.0	3.8	17.09



Зураг 2. календарчилсан төлөвлөгөө


Баяжуулалтын технологи

Баяжуулах хэсгийн ажиллах горим, хүчин чадал

Ордын баяжуулах хэсгийн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, ил уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, уурхайн жилийн хүчин чадал зэрэгтэй уялдаж ажиллана. Баяжуулах хэсэг 2024 онд 48.2 мян.м³ элс баяжуулах ба дунджаар 130 хоног ажиллана. 2024 онд нийт 676.6 мян.м³ хөрс хуулж, дунджаар 457.7 мг/м³ агуулгатай 48.2 мян.м³ элс олборлон баяжуулж 17.09 кг алт /химийн цэврээр/ гарган борлуулахаар байна.

Хүснэгт 12. Баяжуулах цехийн бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 онд
1	Угаах элсний хэмжээ	мян.м ³	48.2
2	Угаах элсний дундаж агуулга	мг/м ³	475.7
3	Металл /химийн цэвр/	кг	18.4
4	Металл авалт	%	92.83
5	Бүтээгдэхүүн гаргалт /химийн цэвр/	кг	17.1
6	Хаягдал гаалийн хэмжээ	мян.м ³	22.1
7	Хаягдал эфелийн хэмжээ	мян.м ³	26.1
8	Хаягдал эфелийн дундаж агуулга	мг/м ³	50.6
9	Хаягдал эфель дэх алтны хэмжээ	кг	1.3



Зураг 3. Тоног төхөөрөмжийн холболтын схем

ДЭД БҮТЭЦ

Усан хангамж

Технологиуд шаардлагатай усны хэмжээ.

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 15%-ийг цэвэр усаар сэлбэх ба 85%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м³ элс угаахад 2.11 м³ ус хэрэглэхээр тооцоолов.

Хүснэгт 2. Угаах процесст зарцуулагдах усны хэрэгцээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 онд			Нийт уулын ажлын хэмжээ
			II-р улирал	III-р улирал	IV-р улирал	
1	Угаах элсний хэмжээ	мян.м ³	15.28	20.89	12.00	48.18
2	1 м ³ элс угаахад зарцуулах усны хэмжээ	м ³	2.11	2.11	2.11	2.11
3	Технологит зарцуулах нийт усны хэмжээ	мян.м ³	32.24	44.09	25.32	101.66
	Цэвэр усны хэмжээ 15%	мян.м ³	4.837	6.613	3.799	15.25
	Эргэлтийн усны хэмжээ 85%	мян.м ³	27.4	37.5	21.5	86.41

Хүснэгтээс үзэхэд угаах процесст зарцуулах цэвэр усны хэмжээ 2024 онд 15.25 мян.м³ байна. Нийт зарцуулагдах усны 85%-ийг эргэлтэд оруулж 15%-ийг цэвэр усаар сэлбэнэ. Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ. *Унд ахуйн усны хэрэглээ.* Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд байнга 51 хүн ажиллаж амьдарна. Оршин суугч нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжинд буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 20-200л/хон байна. Хоногт зарцуулагдах хэрэглээний усны 1 хүнд оногдох хэмжээ дунджаар 150 л гэж үзвэл, нийт хэмжээ 7650 л буюу 7.6 м³/хон (0.09 л/сек) болно. Унд ахуйн усны хэрэгцээг хотхонд гаргасан гүний худгаас хангахаар төлөвлөв.

Хүснэгт 3. Уурхайн нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 онд
1	Технологийн замын тоосжилт дарах	м ³ /жил	3680
2	Баяжуулах үйлдвэрт	м ³ /жил	15248
3	Унд ахуйд	м ³ /жил	1269
	Нийт	м ³ /жил	20197

Уурхайн цахилгаан хангамж

Төслийн талбай нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос 704 км, Баяндун сумаас хойд зүгт 35 орчим километрийн зайнд дэд бүтцээс алслагдсан дүүрэгт байрлана. Иймд төслийн цахилгаан хангамжийг дизель цахилгаан үүсгүүрээр хангахаар шийдвэрлэсэн.

Хүснэгт 4. Ил уурхайн цахилгаан хэрэглэгчид

№	Цахилгаан хэрэглэгчид	Тоо ширхэг	Суурилагдсан чадал, кВт		Эрэлт хэрэгцээний коэффициент	Тооцооны актив чадал, кВт (P _t)	cosφ _t	tgφ _t	Тооцооны реактив чадал, кВАр (Q _t)
			Нэгжийн заасан чадал	Нийт заасан чадал					
1	Угаах төхөөрөмж	1	15	15	0.95	14.25	0.8	0.75	10.69
	Тунаах машин	1	4.4	4.4	0.95	4.18	0.8	0.75	3.14
2	Уурхайн гэрэлтүүлэг	3	1.5	4.5	0.7	3.15	0.9	0.85	2.68
3	Эргэлтийн усны насос	1	37	37	0.95	35.15	0.85	0.62	21.79
4	Ус татах насос	1	15	15	0.9	13.5	0.85	0.62	8.37
5	Засварын газар	1	18	18	0.7	12.6	0.7	1.02	12.85
6	Уурхайн хотхон	1	20	20	0.9	18	0.7	1.02	18.36
7	Бусад тооцоологдоогүй хэрэглэгчид, 5%					5.0			3.89
	Нийт дүн					105.87			81.77

Барилга байгууламж

Уурхайн гадаргуугийн ерөнхий төлөвлөгөөнд уурхай, үржил шимт хөрсний овоолго, уурхайн хотхон, засварын газар, угаах төхөөрөмж, цэвэр бохир нуурын байрлал, авто зам зэрэг барилга байгууламж орно. Уурхайн хотхон, баяжуулах хэсгийн талбай, дотоод тээврийн авто замыг уурхайтай ердийн замаар холбоно.

Хүснэгт 5. Уурхайн барилга байгууламжуудын байршил, эзлэх талбай

№	Эдэлбэр газрын нэр	Талбайн хэмжээ, га	Уурхайгаас алслагдсан зай, м
1	Уурхай	5	
2	Үржил шимт хөрсний овоолго 1	0.5	30м /Уурхайн зүүн талд/
4	Хөрсний гадаад овоолго	3.5	110м /Уурхайн зүүн талд/
5	Хотхон	0.9	6640 м /Уурхайн баруун урд талд/
6	Засварын талбай	0.6	95 м / Уурхайн баруун урд талд/
7	Баяжуулах хэсэг /усан сан, угаан баяжуулах хэсэг/	4.5	200 м /Уурхайн урд талд/
	Авто зам	2.4	
	Нийт дүн	17.4	

Уурхайн нийт эдэлбэр газарт 2024 оны эцсийн байдлаар 17.4 га талбай хамрагдах ба ил уурхайн 17.4 га талбайд дотоод овоолгоор ашиглалтын ажилтай зэрэгцэн техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй. Талбайн өмнө хэсэгт өргөргийн дагуу Улз голын уулс хоорондын хотгор 10 км хүртэл өргөнтэй зурвас хэлбэрээр оршино. Улз, Түргэн голын уулзвар хэсэгт хотгорын өргөн хамгийн их бөгөөд, энд Бүүргэний их нуур (Цагаан нуур), Бүүргэний бага нуурууд орших ба үнэмлэхүй хотгор нь 790 м юм.

Амьтан ургамлын аймаг: Ой мод маш сийрэг хэсэгчилсэн байдалтай байдаг. Уулын ар бэлд ихэвчлэн хус, улиас, нарс бүхий холимог ойн жижиг төгөлтэй.

Уулсын гүн жалгуудаар буйлс, монос, тэхийн шээг, бургас нохойн хошуу ургана. Хайгуул хийсэн ордоос баруун хойш 15 км орчмоос хус нарсан ой үргэлжилдэг.

Уур амьсгал. Судалгааны талбай нь Хангайн нурууны өврийн салбар, намхан уулс *Цаг уур:* Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай ба өвөлдөө хур тунадас багатай дулаахан, зундаа хур бороо элбэг байдаг. Агаарын жилийн дундаж хэм 2 - 4 хэм, үнэмлэхүй хүйтэн -36 хэм, үнэмлэхүй дулаан +33 хэм. Хур тунадасны жилийн дундаж 219 мм ба үүний 75 % нь 6 - 8 сард унадаг. Салхины чиг голдуу баруун хойноос чиглэлтэй ба ихэвчлэн салхины хурд хавар 18 - 20 м/сек байна. Хаварт хүчтэй шороон шуурга шуурдаг.

Дэд бүтэц: Зам харилцааны хувьд тус район нь ажил явуулах нөхцөл сайтайд тооцогдоно. Чойбалсан-Эрдэс-Ульханы сайжруулсан шороон зам тус ордын урдуур 8.5 км зайтай өнгөрдөг. Ордоос Чойбалсан хот 240 км, Баяндун сум 30 км, Дашбалбар сум 80 км, Баян уул сум 70 км, Улаанбаатар хот 700 км зайтай.

Мөн Адуун чулууны нүүрсний уурхай 240 км зайтай ба Баяндун сум АН - 2 онгоцны буудалтай. Сумын төвд соёлын төв, хүнсний жижиг үйлдвэр, сумын хүний болон мал эмнэлгийн салбар, 10 жилийн дунд сургууль, АТС холбооны станц, (үүрэн телефон мобиком, юнител чөлөөтэй холбогдоно) шатахуун түгээх станц ажилладаг.

Баяндун сумын хүн амын ихэнх нь буриад бөгөөд бусад аймаг сумуудаас нүүдэллэн ирсэн халх, үзэмчин барга бусад ястнууд амьдарч байна. Энэ нутгийн ард түмэн нүүдлийн мал аж ахуй голлон эрхлэхээс гадна хүнсний төрөл бүрийн ногоо бага хэмжээгээр тариалдаг. Сум нь дөрвөн багтай баг бүр нь өөрийн төвүүдтэй, сум ба багийн төвүүд дээр амьдардаг хүмүүс нь улсын байгууллага, хоршоолол, компаниудад ажиллах буюу хувиараа ажил хөдөлмөр эрхэлдэг байна.

ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

2024 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2024 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах.
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах.
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.

- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Үржил шимт өнгөн хөрсийг хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “ХОТУ” ХХК-ийн Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч “ХОТУ” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх ёстой.

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	9
1	Агаарын чанар Салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцрын агууламж стандарт хэмжээнээс давж болзошгүй	Уурхайн дотоод замыг услах	Тоос босох гадаргуу	Мот/цаг	2000000	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82
		Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	Уурхайн бүх авто машинуудад	-	Дотоод үйл ажиллагааны зардал	2024 он	
		Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон	2024 он	
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Дотоод үйл ажиллагааны зардал	2024 он	
	Нийт				2000000		
2.	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө			Дотоод үйл ажиллагааны зардалд	2024 он	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

							MNS 5850:2008
		Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах	Үйл ажиллагааны зардалд орно			2024 он	
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон				
	Нийт	-					
	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	2024 он	MNS 5916:2008 MNS 5917:2008
		Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай, авто зогсоол	-	1000000	2024 он	MNS 5918:2008
		Шимт хөрсний нөөц бий болгох стандартын дагуу овоолж, ургамалжуулан хадгалах	Дотоод үйл ажиллагааны зардалд			2024 он	
	Нийт	1000000					
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Олон салаа зам гаргахгүй байна.	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	500000	2024 он	
	Нийт					500000	
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 3500000						

2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Техникийн нөхөн сэргээлт. Ордын хувьд ашиглагдсан орон зай буюу уурхайн ухшийг уурхайн олборлолтын эхэн үеэс хоосон орон зай үүсэх үед дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж уулын ажилтай техникийн нөхөн сэргээлтийн ажлыг давхар явуулснаар тодорхой хэмжээний зардлыг хэмнэж байгаа юм. Техникийн нөхөн сэргээлтийг хийх ихэнх зардал нь ашиглалтын зардалд шингэсэн бөгөөд биологийн нөхөн сэргээлт хийхийн өмнө ахин хэвгийжүүлэх дагтаршуулах ажил хийгдэнэ. 2024 оны уулын ажлаар уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орох 5 га талбайгаас 2 га талбайд “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага-MNS 5917:2008” стандарт болон БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, шимт хөрсөөр хучилт хийж гүйцэтгэнэ. 2024 оны хувьд уурхайн ажил эхэлж байгаа тул уурхайн ашиглалтын талбайд биологийн нөхөн сэргээлт хийхгүй.



Зураг 4. Нөхөн сэргээлтийн бүдүүвч

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	
1	Олборлолт явуулсан 2.0 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт	га	2	-	Үйл ажиллагааны зардалд орсон	8-10 сард	MNS 5915:2008, MNS 5917:2008, MNS 17.5.1.19-92, Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал Биологийн (2015 оны А-138)
	Нийт				-		

3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

“ХОТУ” ХХК нь 2024 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баяндун сумаас өгсөн чиглэлийн дагуу сумын нутагт байрлах Наран булгийг хашаалж хамгаалахаар төлөвлөв.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах, тэр бум мод

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжи хнэгж	Тоо хэмжэ э	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүл эххугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Наран булгийн эхийг хамгаалах төлөвлөв.	га	2	-	4000000	5-10 сард	
3	2024 онд 200 ш мод заасан чиглэлд тарихаар төлөвлөв	ш	200		2000000	5-10 сард	Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд
	Нийт				6 000 000		

4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

5. ТҮҮХ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДУРСГАЛТ ЗҮЙЛС

“ХОТУ” ХХК-ийн Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Баяндун сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Болзошгүй зардал 500000 төг төсөвлөсөн.

6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	Ахуйн хог хаягдал	Уурхайн ажилчдаас гарах хатуу хог хаягдлыг сумын ТҮК-тэй гэрээ байгуулах	Дорнод аймгийн Баяндун сумын нэгдсэн хогийн цэгт хогоо нийлүүлэх,	кг	500 000	-	Уурхайн дотоод зардалд орсон.	Хог хаягдлын тухай хууль	
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	Ажилчдын байр байшингийн гадна байршуулах	тоо	500 000	10	500 000		
2	Үйлдвэрийн хог хаягдал	Уурхайд ашиглаж буй машинаас гарсан дугуй, гэрлийн шил, бохир ус	Хаягдал боловсруулах үйлдвэр, дахивар авах цэгт нийлүүлэх	тоо	500 000	-	500 000		
3	Аюултай хог хаягдал.	Машинаас гарсан хаягдал, тос масло болон бусад аюултай бодисууд		тн	500 000	-	500 000		
				2 000 000					

8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах.

Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Үйлдвэрийн аваар осол, саатал гэмтлээс шалтгаалан ажилчид бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлтэй,	Аваар устгах төлөвлөгөөнд заагдсан арга хэмжээнүүдийг авах	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	500 000	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
	Нийт					500 000		

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Хоту” ХХК-ийн Цагаан чулуут хоолойн дунд хэсэг орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний локаль мониторингийн систем байгуулах нь зүйтэй. Мониторингийн цэгийг зөв сонгож, хугацаа, давтамж зэргийг нь оновчтой сонгож өгөх нь чухал юм. Тус төслийн орчимд явуулбал зохих экологийн хяналтын мониторингийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мониторингийн ажлын давтамж, хэмжилт судалгааны ажлыг хариуцах мэргэжилтэн, мониторингийн үзүүлэлт зэргийг доорх хүснэгтэд тусган оруулж өгөв.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Агаар	1. Овоолго, 2. Уурхай, 3. Хотхон, 4. Уурхайн дотоод зам	8-р сард	4 цэгт 1 удаа	100000	400000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж	MNS 4585:2016 MNS 6063:2010 MNS 6768:2019 MNS 3113:1981 MNS 5885:2008 Агаарын тухай хууль 2012.05.17 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль 2010.06.24
2	Хөрс	1. Уурхайн шимт хөрсний овоолго, 2. Ахуйн бохир усны хаягдал орчимд, 3. Эрүүл талбай, 4. Засварын талбай	8-р сард	4 цэгт 1 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 4 цэгт жилд удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 25000 төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 75.0 мян.төг	150000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	MNS 5850 : 2019 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 : 1987 MNS 2305 : 1995
3	Ус	1. Унд ахуйн ус, 2. Цэвэр бохир нуур	8-р сард	3цэгт 1 удаа	Бүрэн шинжилгээний үнэ 150000 төг	450000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ,	MNS /ISO/ 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 4943:2015 MNS 0900:2018 Усны тухай хууль 2012.05.17
	Нийт					1000000		

10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 12. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Усны нөөцийг үр ашигтай ашиглаагүйгээс газрын доорх усны нөөц, горимд өөрчлөлт орно.	Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах	Үүсмэл нуураас хангана	-	-	Усны тухай хууль
Ажилчдын мэдлэг чадвар дутмаг байдлаас ажлын доголдол гарах	Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалт зохион байгуулж байх	Ажилчид	500000	Жил бүр	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
			500000		

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГЫН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.		9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.	-
2		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.		11 сарын 1-нд багтаан			-
	Нийт	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон.					

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 14. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	3500.0
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	4000.0
4	Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	2000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2000.0
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500.0
8	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	500.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1000.0
10	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	500.0
	2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	14000.0

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт 14.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 7.0 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.